



**МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ**

**МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН  
2016 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

/10 жил + 60 тэрбум ам.доллар + 30-р байр = 100 %/

**СОНГУУЛИЙН ХУВЬСГАЛААС  
ХӨГЖЛИЙН ХУВЬСГАЛД**

Улаанбаатар хот 2016



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН  
БАГА ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

УИХ-ын 2016 оны сонгуулийн  
мөрийн хөтөлбөрийг батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3.4 дэх заалт, МАХН-ын дүрмийн 14.4.3 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны сонгуульд оролцох МАХН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг баталсугай. (Мөрийн хөтөлбөрийг хавсралтаар хүргүүлэв)
2. Бага чуулганы гишүүдээс гаргасан санал, дүгнэлтийг судлан үзэж сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгаж, эцэслэн боловсруулж сонгуулийн тухай хуулийн дагуу Монгол Улсын Үндэсний Аудитын газарт хүргүүлэхийг МАХН-ын Гүйцэтгэх товчоонд даалгасугай.
3. Монгол Улсын Их Хурлын 2016 оны сонгуульд МАХН нь улс төрийн бусад намуудтай эвсэн орох тохиолдолд тус хөтөлбөрийг эвслийн мөрийн хөтөлбөрт тусган оруулахыг Гүйцэтгэх товчоонд даалгасугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА

ОРЛОГЧ ДАРГА



Н.УДВАЛ

Ц.ЛХАГВАСҮРЭН

МАХН-ын Бага чуулганы 2016 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн  
13 дугаар хуралдааны 11 дүгээр тогтоолын хавсралт



## МАХН-ЫН 2016 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Уриа: Сонгуулийн хувьсгалаас

Хөгжлийн хувьсгалд

(10 жил + 60 тэрбум ам.доллар + 30-р байр = 100%)

### Нэг. Хөтөлбөрийн зорилго

**Нэгэн зүйл,** Монголчууд Та бид оюуны өндөр чадамжтай, алсын хараатай, эр зоригтой, дэлхийн их гүрнийг байгуулж явсан түүхтэй агуу их ард түмэн мөн билээ. Эцэг өвгөд маань уудам тэнүүн газар нутгаа Оюутолгой, Таван толгойн зэс нүүрсийн нөөцтэй нь, Гачуурт, Төмөртэй, Асгат, Хөшөөтийн алт, төмөр, мөнгө, нүүрсийн нөөцтэй нь, Мардай, Тамсагийн уран, нефтийн баялагтай нь Та бидэнд бүрэн бүтнээр нь өвлүүлэн үлдээжээ. Энэ их өв хөрөнгөтэй, баялаг соёл уламжлалтай улсын иргэд дэлхийн аль ч улс гүрний хүмүүсээс илүү баян тансаг, илүү аз жаргалтай, амар амгалан, эрүүл саруул амьдрах бүрэн эрхтэй билээ.

**Нэгэн зүйл,** Одоо хувь заяаныхаа эзэн нь болох, үр хүүхэддээ баталгаатай ирээдүйг нь бүтээн өгөх, ахмад буурлуудаа дутагдаж гачигдах зүйлгүй, сэтгэл санааг нь амар амгалан байлгах, хүн бүрийг баталгаатай ажлын байртай болгох, бүгдээрээ орлогын найдвартай эх үүсвэртэй болох улс төр, нийгэм, эдийн засгийн цогц бодлого үгүйлэгдэж байна. Хөгжлийн хувьсгал хийх зорилго бүхий бодлого боловсруулан хэрэгжүүлснээр Та бид энхрий хайрт Монгол орноо хоцрогдсон орны арчаагүй байдлаас гаргаж, хөгжилтэй орны нэр хүндтэй байр сууринд аваачих бололцоотой болно.

**Нэгэн зүйл,** Монголын ард түмэн төрдөө итгэх итгэлээ сэргээхийн тулд тогтвортойгоор засаглаж чадах, бүлэг фракцид хуваагдаагүй, эв нэгдэлтэй байх чадвартай, олигархуудын эрх ашигт барьцаалагдаагүй, ард түмнийхээ зовлон жаргалыг мэддэг, тэднийхээ төлөө ажиллах чин хүсэл эрмэлзэлтэй, тодорхой үзэл баримтлалтай улс төрийн хүчнийг хүсэн хүлээж байна. Тэд чухамхүү ийм хариуцлагатай улс төрийн хүчин эх орноо өнөөгийн хямралаас гаргаж, эмх замбараагүй байдлыг цэгцэлж чадна гэж үзэж байна.

**Нэгэн зүйл,** Та бид өнөөдрийн төрд шүүмжлэхээр, засч залруулахаар олон алдаа дутагдал байгааг сайн мэдэж байгаа. МАН ба АН нь хамтарч МАН-АН болоод ч, тус тусдаа засаглаад ч улс орныг хямралт байдлаас гаргаж чадсангүйг нь, тэд улс орныг өр ширэнд улам баригдуулсан буруу бодлого хэрэгжүүлж ирснийг нь ч сайн мэднэ. Тиймээс МАХН нь УИХ-ын 2016 оны сонгуулиар Та бүхнийхээ дэмжлэгийг авч, эх орон, ирээдүй хойч үеийнхээ эрх ашгийг бодон хийж хэрэгжүүлэх томоохон бодлогоо тусгасан “Хөгжлийн хувьсгал” мөрийн хөтөлбөрөө Танд толилуулж байна.

**Нэгэн зүйл,** МАХН-ын дэвшүүлж байгаа “Хөгжлийн хувьсгал” мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол Улс 10 жилийн дотор 60 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татаж, хөгжлөөрөө дэлхийд эхний 30-д буюу хөгжилтэй орны тоонд орох болно. Энэ хугацаанд нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 17,5 мянган ам.долларт хүрнэ.

МАХН нь Та бүхэнтэйгээ хамт Сонгуулийн хувьсгал хийж, үр дүнд нь УИХ-д олонхи болсон тохиолдолд энэхүү “Хөгжлийн хувьсгал” хөтөлбөр дөрөв дөрвөн жилийн нарийвчилсан төлөвлөгөөний хэлбэрт орж, амжилттай хэрэгжих баталгаа 100 хувь байх болно.

### **Хоёр. Ажлын байр, ажлын байр, дахин ажлын байр буюу хөтөлбөрийн зорилтууд**

1. Олон түмний тав тухыг хангасан, орчин үеийн шийдэл бүхий “Жаргалын 8 хот” байгуулах ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

Эдгээр хотын бүтээн байгуулалт болон үйлдвэр үйлчилгээ, хөдөө аж ахуй, хүнсний салбарт 10 жилд нийт 600 мянган, жил бүр дунджаар 60 мянган ажлын байр шинээр бий болгох ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

2. “Хөгжлийг тэтгэсэн цахилгаан станц” буюу 3500 мегаваттаас доошгүй хүчин чадалтай эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

3. Холыг ойртуулах, үйлчилгээг хурдасган чанаржуулах, бараа, үйлчилгээний үнийг бууруулах “Мянганы төмөр зам” барих ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

4. “Тэг түрээсийн орон сууц”-аар нийт 450,000 айл өрхийг орон сууцжуулах ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

5. Оюутны сургалтын төлбөрийг төрөөс 100 хувь хариуцдаг болох “Төрийн тэтгэлэг”-т 10 жилийн дотор үе шаттайгаар бүрэн шилжих ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

6. Ахмад настан, эх хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдын эрүүл мэндийн үйлчилгээг төрөөс 100 хувь хариуцдаг болох “Эрүүл мэндийн хамгаалалт”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

7. “Их бүтээн байгуулалт”-ын төсөл, “Жаргалын найман хот”, дэд бүтцийн бусад төслүүдийг хэрэгжүүлснээр сард 5 сая төгрөгийн орлоготой чинээлэг дундаж өрхийг нийгмийн олонхи болгох ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

8. Мал эмнэлгийн үйлчилгээг бүрэн сэргээн хөгжүүлж, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн салбарт төрийн бодитой дэмжлэг бүхий орон нутгийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг судлаж, эрх зүйн орчныг бий болгоно.

Санхүү, эдийн засгийн тооцоо судалгаа гаргаж үзвээс эдгээр зорилт нь дөрөв дөрвөн жилээр тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжих бүрэн боломжтой бөгөөд



гарах үр дүн нь Монгол орны өмнө тулгамдаад байгаа улс төр, нийгэм, эдийн засгийн олон асуудлыг иж бүрэн шийдвэрлүүлэх ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.

Энэхүү хөтөлбөрийн гол зорилго Монгол хүн бүрийг “эзэн хичээвэл заяа хичээнэ” хэмээх зарчмын дагуу авьяас чадвараа нээн хөгжүүлэх, баталгаатай ажилтай, найдвартай орлоготой болгох, сэтгэл хангалуун амьдрах нөхцлийг бүрдүүлэх, томоохон бүтээн байгуулалтын их үйлсийг өрнүүлэн улс орноо эрчимтэй хөгжүүлэх, Монгол Улсыг түүхийн богино хугацаанд дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын хөгжлийн түвшинд хүргэхэд оршино.

### **Гурав. Хүнд сурталгүй Монгол Улс буюу хөтөлбөрийн үйл ажиллагаа**

1. “Жаргалын 8 хот” байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1.1. Дунджаар 150 000 (нэг зуун тавин мянган) хүн ам бүхий улсын чанартай 8 хотыг байгуулах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно. (1.Чойбалсан хот, 2.Чингис хот, 3.Дархан хот, 4.Эрдэнэт хот, 5.Чойр хот, 6.Хархорин хот, 7.Улиастай хот, 8.Ховд хот).

1.2. Чойбалсан хот, Чингис хот, Чойр хот, Дархан хот, Эрдэнэт хот, Хархорин хот, Улиастай хот, Ховд хот зэрэг найман хотыг төмөрлөг, хими, эрчим хүчний үйлдвэрлэл бүхий аж үйлдвэр, инновацийн цогцолбор төв болгож хөгжүүлэх ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.

1.3. Хот тус бүрийг өөрийн онцлогт тохирсон их дээд сургууль, иж бүрэн цогцолбор эмнэлэг, соёл урлаг, биеийн тамир спортын төвтэй болгох ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.

1.4. Барилгын материал, үйлдвэрлэл технологийн паркуудыг хөгжүүлэх ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.


2. “Хөгжлийг тэтгэсэн цахилгаан станц” буюу 3500 мегаваттаас доошгүй хүчин чадалтай эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох” зорилтын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1. 3500 мегаваттын хүчин чадал бүхий эрчим хүчний шинэ эх үүсвэрийг барьж байгуулах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.


2.2. Эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, улмаар хөтөлбөр хэрэгжих арван жилийн хугацаанд түүний эзлэх хувийг олон улсын жишигт ойртуулах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.

2.3. Хот суурины айл өрх, албан байгууллагын сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг урамшуулж, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг дэмжих бодлого гаргах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.

2.4. Айл өрх бүрийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангана. Чингэхдээ: (а) хот суурин орчмын айл өрхийг эрчим хүчний сүлжээнд холбоно, (б) малчдыг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.




- 2.5. Монгол Улс эрчим хүчээр өөрийгөө бүрэн хангаж, эрчим хүч экспортлогч орон болох ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.
3. “Мянганы төмөр зам барих” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.1. Монгол Улсын Зүүн хязгаарыг Баруун хязгаартай холбосон 3500 (гурван мянга таван зуун) км урттай “Мянганы төмөр зам”-ын хэвтээ болон босоо тэнхлэгийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно. (Чойбалсан хотоос Ховд хот хүртэл хэвтээ тэнхлэгтэй, Дорнодын Эрээнцавын хилийн боомтоос Сүхбаатарын Бичигтийн хилийн боомт хүртэл, Сэлэнгийн Сүхбаатарын хилийн боомтоос Дорноговийн Замын-Үүдийн хилийн боомт хүртэл, Завханы Арц суурийн хилийн боомтоос Өмнөговийн Ширээ хүрэнгийн хилийн боомт хүртэл, Баян-Өлгийн Цагааннуурын хилийн боомтоос Ховдын Булганы хилийн боомт хүртэл нийт дөрвөн босоо тэнхлэгтэй, улсын чанартай 8 хотыг хооронд нь холбосон нэгдсэн төмөр замын сүлжээ).
- 3.2. Улсын чанартай хотуудыг Улаанбаатар хоттой болон хооронд нь холбосон “Мянганы төмөр зам”-ыг цахилгаанжуулж, дунджаар 150 км/ц-аас доошгүй хурдтай, зорчигч болон ачаа тээврийн галт тэрэг зорчих шаардлагыг хангасан байх эрх зүйн орчныг бий болгоно.
- 3.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг холбосон төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.
- 3.4. Цахилгаанжсан “Мянганы төмөр зам”-ын зорчигч болон ачаа тээврийн дэд бүтцийг хөрш орнууд буюу ОХУ болон БНХАУ-ын төмөр замын дэд бүтэцтэй холбож олон улсын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно. Бүтээн байгуулалтын энэ ажлын хүрээнд Дорнодын Эрээнцавын хилийн боомтоос Сүхбаатарын Бичигтийн хилийн боомт хүртэл, Сэлэнгийн Сүхбаатарын хилийн боомтоос Дорноговийн Замын-Үүдийн хилийн боомт хүртэл, Завханы Арц суурийн хилийн боомтоос Өмнөговийн Ширээ хүрэнгийн хилийн боомт хүртэл, Баян-Өлгийн Цагааннуурын хилийн боомтоос Ховдын Булганы хилийн боомт хүртэл нийт дөрвөн босоо тэнхлэгтэй төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
4. “Тэг түрээсийн орон сууц”-аар 450,000 айл өрхийг хангах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.1. Улсын хэмжээнд нийт 450 000 (дөрвөн зуун тавин мянган) айл өрхийг орон сууцанд оруулах ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.
- 4.2. “Тэг түрээс”-ийн орон сууцны талбайн дундаж хэмжээ 60 ам дөрвөлжин метр байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.3. Орон сууцны хотхон, хорооллуудыг тэнд оршин сууж байгаа хүмүүст таатай орчин үеийн амьдралын хэв маягт нийцүүлэн барих ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.



5. Оюутны сургалтын төлбөрийг төрөөс 100 хувь хариуцах “Төрийн тэтгэлэг”-т 10 жилийн дотор үе шаттайгаар бүрэн шилжих зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.1. Хөтөлбөр хэрэгжих арван жилийн хугацаанд төрийн өмчит их дээд сургууль, коллежийн оюутны сургалтын төлбөрийг төр бүрэн хариуцах тогтолцоо руу үе шаттайгаар буюу бүрэн шилжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
- 5.2. Их дээд сургуулийн сургалт, шинжилгээ судалгааг шинжлэх ухаан, үндэсний үйлдвэрлэл, олон улсын төсөлтэй холбох замаар чанаржуулж, олон улсын жишигт хүргэх эрх зүйн орчныг бий болгоно.
- 5.3. Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах их, дээд сургуулийн төсвийн хэмжээг үе шаттайгаар олон улсын жишигт хүргэх ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.
- 5.4. Их дээд сургуулиар бэлтгэж байгаа мэргэжлийн чиглэл, төгсөгчдийн чадавхийг үндэсний эдийн засгийн бүтэц, техник технологийн хөгжлийн чиг хандлагатай нягт уялдуулна.
- 5.5. Мэргэжлийн чиг баримжааг тодорхойлох зөвлөх үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлдэг тогтолцоог бий болгох ажлыг судлаж эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 5.6. Их дээд сургуулиуд, шинжлэх ухааны паркуудыг нийслэл болон улсын чанартай найман хотод төрөлжүүлэн байгуулж, шинжлэх ухааны салбар салбараар дагнан хөгжүүлэх нөхцлийг судлаж эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санаачлага гарган ажиллана.
- 5.7. Шинжлэх ухаан, технологийн судалгаанд төсвөөс зарцуулах зардлын хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувьд хүргэж өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүргэх тогтолцоог бий болгоно.
- 5.8. Их дээд сургуулиудын дэргэд шинжлэх ухааны нээлт, шинэ ололтыг хэрэглээ, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх инкубатор төв байгуулж ажиллуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.
6. Ахмад настан, эх хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдын эрүүл мэндийн үйлчилгээг төрөөс хариуцах “Эрүүл мэндийн хамгаалалт”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.1. Эрүүл мэндийн хувьд хамгийн их эрсдэлд өртөмтгий ахмад настан, эх хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдын эрүүл мэндийн үйлчилгээг төрөөс хариуцдаг тогтолцоо руу үе шаттайгаар бүрэн шилжих ажлыг судлаж эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санаачлага гаргаж ажиллана.
- 6.2. Ахмад настан, эх хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдын хамрагдах эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо, давтамжийг нэмэгдүүлж, үзлэгт бүрэн хамруулдаг тогтолцоог бий болгоно.



- 6.3. Өвчин эмгэгээс урьдчилсан сэргийлэх “Эрт илрүүлгийн үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, өвчлөл нас баралтын зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулж, Монгол хүний дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.
- 6.4. Эх орондоо чанартай, өндөр нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг үзүүлэх чадавхийг бүрдүүлж, өвчтөн үйлчлүүлэгчдийн чирэгдэлийг бууруулна. Эрүүл мэндээс шалтгаантай эдийн засгийн ачааллыг бууруулна. “Жаргалын найман хот”-д улсын чанартай оношилгоо, эмчилгээний төвүүдийг байгуулах ажлыг судлаж эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.
7. “Их бүтээн байгуулалт”-ын төсөл, “Жаргалын найман хот”, дэд бүтцийн төслүүд хэрэгжсэнээр сард 5 сая төгрөгийн орлоготой “ЧИНЭЭЛЭГ ДУНДАЖ ӨРХ”-ийг нийгмийн олонхи болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.1. Төр, хувийн хэвшлийн байгууллагуудад хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, цагийн хөлсний үнэлгээг олон улсын жишигт хүргэн нэмэгдүүлэх боломж бололцоог бий болгоно.
- 7.2. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт оновчтой, тэгш, хүртээмжтэй байдлаар олгох замаар халамжийн тогтолцоог боловсронгуй болгох хууль эрх зүйн орчныг бий болгоно.
- 7.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх иргэдэд төрөөс эдийн засаг, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгон зах зээлийн тогтвортой орчныг бүрдүүлж, гарааны бизнесийг дэмжих “Бизнес хөгжлийн сан” байгуулах талаар санаачлага гаргаж ажиллана.
- 7.4. Олон улсын түвшинд өрсөлдөхүйц, монгол хүний оюун ухаан шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр гаргахаар ажиллаж байгаа байгууллага, иргэдэд төрөөс зээл, татварын бодлогоор дамжуулан онцгойлон дэмжлэг үзүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгоно.
- 7.5. Өнөөдөр Монголд жижиг дунд бизнес эрхлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа зүйл бол бүх шатны хүнд суртал, тоо томшгүй олон зөвшөөрөл авах шаардлага, хээл хахууль мөн билээ. Бид төрийн алба өнөөгийн хээл хахууль авах ба өгөх, хүнд суртал гаргах, иргэддээ хатуурхахын “дээд сургууль” болж байгааг болиулж, төрийн байгууллагуудын үйлчилгээнд “иргэний өргөдөл шууд зөвшөөрөл” болдог журмыг хуульчлан нэвтрүүлж, хүнд суртал хөнгөн шуурхай үйлчилгээ болгоно.
- 7.6. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэхэд нь тодорхой хугацаанд татварыг нь тэглэх, бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байхад нь дааж давшгүй татварын дарамтанд оруулахгүй байх, тансаг хэрэглээ болон уул уурхайн чиглэлийн бизнес эрхлэгчдээс өндөр татвар авах зэргээр татварын шатлалтай шударга тогтолцоо нэвтрүүлж, ажлын байр шинээр бий болгоход нь болон иргэд найдвартай орлогын эх үүсвэртэй болоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, хууль эрх зүйн орчныг сайжруулна.






8. Газар дээрх амьтан ургамал, мод бут, шувуу, ан амьтад зэрэг нь үнэлж баршгүй баялаг мөн. Ан амьтан, ургамал, бэлчээрийг “Хамгаалан эзэмших нөхөрлөл”-үүдийг сумандаа амьдарч буй нутгийн иргэдээс бүрдүүлэх, гэрээний үндсэн дээр тодорхой хүрээний ан амьтан, ургамлыг нөхөрлөлийн хамгаалалт, арчлалтад өгч эзэнтэй болгон, зүй зохистой ашиглан үр шимийг нь хүртээх ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно.
- 8.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдан авдаг төрийн өмчийн оролцоотой худалдааны компани байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 8.2. Газар тариалангийн салбарыг дэмжих чиг үүрэг бүхий төрөлжсөн “Тариалангийн банк” байгуулах эрх зүйн орчныг бий болгоно.
- 8.3. Мал эрүүлжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхийн тулд төрийн өмчийн хэлбэрээр мал эмнэлгийн тогтолцоог цогцоор нь шинэчилнэ.
- 8.4. Хот суурин газруудын ойролцоо сүү, махны чиглэлийн мал үржүүлэх, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах чиглэлтэй хөдөө аж ахуйн фермерийн цогцолборыг байгуулан хөгжүүлэх ажлыг судлаж эрх зүйн орчныг бий болгоно. Тэдгээр фермерийн цогцолборын хүрээнд таримал тэжээл ба таримал бэлчээр байгуулах, түүнчлэн гахай, шувуу, загас, зөгий үржүүлэх замаар тус фермерийн цогцолборуудын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний борлуулалт, нийлүүлэлтийг баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

#### **Дөрөв. Хөгжлийн хувьсгал хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам**

##### **“СОНГУУЛИЙН ХУВЬСГАЛ”**

Төрийн эрх мэдлийг олигархиудын гараас ард түмний гарт хуулийн хүрээнд сонгуулиар шилжүүлэхийг **Сонгуулийн хувьсгал хийх** гэнэ. Ташуураар хамгаалсан тусгаар тогтнолоо сонголтоороо хамгаалах цаг ирсэн тул Сонгогч бүр идэвхгүй байдлаасаа сэрэн сэхээрч, сонгох, сонгогдох эрхээ ухамсайртайгаар эдэлж, сонгуульдаа идэвхтэй оролцож, олигархиудаас засгийн эрхээ салган авах **Сонгуулийн хувьсгалыг хамтдаа** хийцгээе. Үүний тулд:

- 4.1. Сонгуулийн авлига өгөх замаар, төрийн эрхийг мөнгөөр худалдан авах, сонгуулийн дараа авлига авах замаар эх орноо худалдан тэрбумтан болдог байдлыг бүрэн хална.
- 4.2. Сонгуулийг улс төр бизнесийн бүлэглэлүүдээс хараат бус хөндлөнгийн, шударга иргэдийн хяналтанд явуулдаг болно.
- 4.3. Сонгуулийн булхай луйврыг илчилж, мэдээлэх, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж, шударга бусаар төрийн эрхэнд гарсан нам, улс төрчдөд хариуцлага хүлээлгэнэ.
- 4.4. Монгол төрийн “Хүний нөөцийн алтан сан” бүрдүүлнэ. Намын харъяалал, нас, хүйс, яс үндэс, зүс царай харгалзахгүйгээр Монгол Улсын хөгжлийн төлөө чин сэтгэлээсээ зүтгэх хүмүүсээр төрийн албыг бүрдүүлнэ.



- 4.5. Нэр цэвэр, хариуцлагатай, ёс зүйтэй, эх орныхоо хөгжлийн төлөө зүтгэх чин сэтгэлтэй хүмүүсийг тодруулан УИХ-д нэр дэвшүүлэн сонгуулах замаар улс төрд чадварлаг үеийг гаргаж, дадлага туршлагатай төрийн зүтгэлтнүүд болон ахмад үеийнхний мэдлэг, туршлага, үнэ цэнэтэй сургаалийг төрийн хар хайрцагны бодлогоор уламжлуулан үлдээдэг болгоно.
- 4.6. Ард түмний ашиг сонирхлын эсрэг шийдвэр гаргасан, хууль тогтоомж санаачилсан, ёс зүйн ноцтой алдаа дутагдал гаргаж, ард түмнээ үл хүндэтгэсэн, улс орны хөгжлийг хойш татаж, хувийн болон бусад явцуу бүлгийн эрх ашгийг хамгаалсан, ард түмнийг хууран мэхэлсэн улс төрийн өндөр албан тушаалтнуудыг хугацаанаас нь өмнө албан тушаалаас нь огцруулдаг оновчтой арга механизмыг хуульчлан тогтоож хэрэгжүүлнэ. Чингэхдээ ард түмнийхээ дэмжлэгт шууд тулгуурлах зарчмыг баримтлана.
- 4.7. Өндөр албан тушаалаа болон хууль, шүүхийн байгууллагыг гар хөлөө болгон ашиглаж, хээл хахуулийг авч өгөх ажлыг улс үндэстнээ сүйрүүлэх хэмжээнд аваачсан өнөөгийн зарим эрх баригчдын явуулж байгаа балмад үйл ажиллагааг таслан зогсооно.
- 4.8. Хэлмэгдүүлэлийн аргаар улс төрийн өрсөлдөгчөө нухчин дарах, Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхэд бүдүүлгээр халдах замаар төрийн эрх мэдлийг хэтрүүлэн хэрэглэж, ард түмнээ айдас хүйдэст автуулж байгаа байдлыг засч, цаашид албан тушаалтнууд хоорондоо зөрчилд автсаны хохирлыг ард түмэн амсдаггүй, шударга шүүх засаглалтай орон болж, Дүр эсгэсэн ардчилалыг халж, жинхэнэ ардчилалыг сэргээн бат бэх тогтооно.


#### **ТАВ. ХӨГЖЛИЙН ХУВЬСГАЛЫН ҮР ДҮН**

*Шинэ хотын иргэдэд дараах боломж нээгдэнэ.*

**Баталгаатай ажлын байртай болно.** 10 жилийн хугацаанд бүтээн байгуулалтын их үйлс өрнөх учир нийтдээ 600 мянга, жил бүр дунджаар 60 мянган ажлын байр шинээр бий болно.

**Өндөр цалин хангамжтай болно.** Их бүтээн байгуулалтын үйлс өрнөснөөр хөдөлмөрийн бүтээмж, үнэлгээ аль аль нь сайжирч цалин, урамшууллын шинэ систем нэвтэрч, иргэдийн орлого нэмэгдэж, улмаар 10 жилийн дараа нэг өрхийн дундаж орлого нэг сард 5 сая төгрөг болно.

**Бизнесийн шинэ боломж нээгдэнэ.** “Жаргалын 8 хот”-ын бүтээн байгуулалтад барилга, зам, эрчим хүч зэрэг дэд бүтцийг барьж байгуулах ажлын захиалга огцом нэмэгдэнэ. Эдгээр хотын иргэдэд зориулсан хүнсний үйлдвэрүүд байгуулагдана, урлаг соёлын үйлчилгээ сайжирна нийтийн хоолны бизнес хөгжинө, хүнсний барааны дэлгүүрүүд нээгдэнэ, машин техникийн худалдааны төв, засварын газар байгуулагдана. Энэ мэтээр бизнесийн шинэ шинэ боломжууд нээгдэнэ. Төв суурин газраас алслагдмал хэмээн тооцогддог байсан аймаг, сумын иргэдэд зах зээл ойртож, мах, сүү, тариа ногоо зэрэг хүнсний бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэж, хөдөөний иргэдийн орлого нэмэгдэнэ. Шинээр бизнес эхлүүлэх хүсэлтэй иргэдийг



хөрөнгө мөнгөний эх үүсвэртэй болгохын тулд “Жижиг, дунд бизнес дэмжих сан” байгуулж, санхүү, зээлийн таатай нөхцлийг бүрдүүлнэ.


**Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хамгийн сайн үйлчилгээг нэвтрүүлнэ.** Шинээр төлөвлөгдөж буй хотуудад олон улсын жишигт нийцсэн оношилгоо, эмчилгээний төвүүд баригдаж, иргэддээ эрүүл мэндийн чанартай үйлчилгээ үзүүлэх боломж буй болж, ингэснээр алслагдмал нутгийн өвчтэй иргэдийн хувьд Улаанбаатар хотод ирж, эсхүл гадаадад явж эмчлүүлэх шаардлага алга болно. Нийслэлийн эмнэлгүүдийн ачаалал багасч, тэдгээрийн үзүүлж буй эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж мэдэгдэхүйц сайжирна. Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцлийг өргөжүүлж, утаа тоосгүй хотуудыг хөгжүүлснээр нийтийн эрүүл мэнд сайжирна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хот төлөвлөлт, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээг цогцоор нь бодитойгоор нэвтрүүлнэ. Шинэ хотын иргэд, шинээр төрсөн эх хүүхдүүдэд онцгой халамж тавьж, хүн амын өсөлтийг дэмжинэ. Тухайлбал төрсөн эхийг хүүхдээ 3 нас хүртэл харсныг ажилласанд тооцож цалинжуулдаг болно.

**Тав тухтай амьдрах орон сууцтай болно.** Орчин үеийн шийдэл бүхий хотууд баригдаж айл бүр төвлөрсөн дулаан, дэд бүтэц бүхий тав тухтай орон сууцанд амьдарна. Ахмадууд амрах, хүүхэд тоглох, залуучууд спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулагдсан шинэ хотын стандартыг нэвтрүүлнэ. Цэцэрлэг, сургуулиудад хүүхдэд ээлтэй, сурч боловсроход нь тохиромжтой орчин нөхцлийг бүрэн бүрдүүлсэн байна. Авто машины зам, гудамж талбай нь өргөн цэлгэр, явган хүний болон дугуйн зам нь орчин үеийн жишиг хотын адилаар төлөвлөгдөж байгуулагдана.

**Үр хүүхдээ өндөр боловсрол эзэмшүүлэх боломжтой болно.** Ерөнхий боловсролын сургуулиуд нь нэг багшид ногдох хүүхдийн стандарт тоог баримтлах боломжтой болж, сургалтын чанар эрс сайжирна. Хот бүрт улсын томоохон их дээд сургуулиудыг шилжүүлэн байгуулах учраас тухайн хотдоо өндөр мэргэжил эзэмших боломжтой болно. Их дээд сургуулиудыг дотуур байр, лабораторитой нь цогцолбороор нь барьж байгуулах тул оюутнуудад тохиолддог дотуур байрны хүрэлцээ гэх мэт ахуйн бэрхшээлийг арилгаж, үр дүнтэй суралцах боломжийг нь бүрэн гүйцэд олгоно.

**Гэмт хэрэггүй, зөрчилгүй, амар амгалан хотууд бий болно.** Ажилгүйдлийг арилгаж, нийгмийн аливаа дарамтыг бууруулснаар хулгай дээрэм, бусад гэмт хэргийн гаралт эрс багасч, хотын иргэд амар тайван амьдрах нөхцөл хангагдана. Иргэдийн төлөө, нийгмийн амар амгаланг хамгаалан ажиллах хууль сахиулагч, гэмт хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх шударга шүүгчийг иргэдийн саналаар сонгодог болсноор хүний эрхийг дээд зэргээр хангах хууль зүйн орчинг бүрдүүлнэ. Хэв журмын зөрчлийг хянаж баримтжуулах камерийн системийг хот бүрт байгуулна.

**Алс холын ялгаа арилж, аялж жуулчлахад таатай нөхцөл бүрдэнэ.** Бүх хотыг “Мянганы төмөр зам”-аар холбох учраас газар хол, зам муу гэх ойлголт байхгүй болно. Монголын болон гадаадын аялагч, жуулчид “Мянганы авто зам”, “Мянганы төмөр зам”-аар хүссэн газартаа саадгүй очиж, цаг заваа хэмнэнэ. Аялал жуулчлалаас орох орлого эрс нэмэгдэнэ. Ачаа барааны эргэлт сайжирч, Ази Европыг



холбосон шинэ бизнесийн боломж нээгдэнэ. Түүхий эдээ хямд өртөгтэйгээр татан авах боломжтой болсноор үндэсний үйлдвэрлэл хөгжих үндсэн нөхцөл бүрдэнэ.

**Утаагүй цэнгэг агаартай хотууд бий болно.** Шинэ хотын иргэд тохилог орон сууцаар бүрэн хангагдах тул агаарын бохирдол эрс багасч арилна. Дулааны болон эрчим хүчний цахилгаан станцуудыг барьж байгуулна. Ингэснээр 3500 МВт-ын эрчим хүчний шинэ эх үүсвэр буй болох тул айл өрхүүд хямд үнэтэй цахилгаан хэрэглэнэ. 3500 МВт эрчим хүч үйлдвэрлэснээр шинэ хотуудыг эрчим хүчээр хангаад зогсохгүй эрчим хүч экспортлон валютын орлого олох боломж бололцоо нэмэгдэнэ.

**Өндөр технологи, инновацийг хөгжүүлэх боломжтой болно.** Иргэдийн амьдрах орчин дээшилж, боловсролын чанар сайжирснаар залуучууд бизнес эрхэлж, оюуны багтаамж бүхий нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах боломжтой болно. Шинэ хотуудыг төрөлжүүлэн хөгжүүлэх бодлого баримтлахдаа “Монгол автомашины үйлдвэрлэл”, “Хими технологийн парк”, “Хөдөө аж ахуйн хөгжил”, “Монгол дизайн”, “Аялал жуулчлал”, “Мэдээллийн технологи” зэрэг хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ. Ингэснээр монгол хүний авъяас чадвар нээгдэн хөгжиж, дэлхийд үнэлэгдэх болно.

**Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг болно.** Монголын гар урчууд, нийт уран бүтээлчдэд бүтээлээ туурвихад нь таатай орчинг бүрдүүлж, тэдний оюуны өмчийн эрхийг баталгаатай хамгаална. Хүнсний ногоо, газар тариалан эрхлэгчид, мах, сүү, ноос, ноолуур болон мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, жижиг дунд бизнес эрхлэгчдийн хийж бүтээсэн бараа бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр худалдан авч, нэгдсэн журмаар гадаадын зах зээлд экспортлон гаргадаг тогтолцоог бий болгоно.


*Сумандаа амьдарч буй иргэдэд дараах боломж нээгдэнэ*

**Шинэ хотод шилжин амьдрах боломж нээгдэнэ.** Ажил хөдөлмөр, шинэ бизнес эрхлэх, тохилог байр орон сууцтай болох, үр хүүхдүүддээ сайн боловсрол олгох, эрүүл мэндийн чанартай үйлчилгээнд хамрагдах зэрэг шинэ хотын бүхий л давуу талыг хүртэх бодит боломжтой болно.

**Хямд, чанартай бараа бүтээгдэхүүн хэрэглэх боломжтой болно.** Өөрийн хүссэн, эсхүл аль ойрхон хотдоо очиж, тэнд байгуулагдсан хүнс, бараа, техникийн зах, худалдааны төвүүдээс чанартай бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр худалдан авч хэрэглэх боломжтой болно.

**Бизнесийн шинэ шинэ боломж нэмэгдэнэ.** Өөрийн хүссэн хотод шинээр бизнес эрхлэх, өөрийн мал аж ахуйгаас гарсан мах, сүү, тариа, ногоо бусад бараа бүтээгдэхүүнийг борлуулах, аж ахуйгаа томруулан хөгжүүлэх, орчин үеийн фермерийн аж ахуй байгуулах нөхцөл эрс сайжирна.

**Байгалын баялгаас шинэ орлогын эх үүсвэртэй болно.** Зэрлэг ан амьтан, ургамал ногоог иргэдийн байгуулсан “Хариуцан хамгаалах нөхөрлөл”-д эзэмшүүлж хамгаалуулна. Олон улсын гэрээ конвенцийн дагуу өсгөн үржүүлж хамгаалсан бол эзэмших эрх нээгддэг учир өсгөн үржүүлсэн ан амьтан, ургамал зэрэг байгалын баялгаас иргэд ашиг олох нөхцлийг хангаж өгнө. Ингэснээр тусгай зөвшөөрлөөр хэдхэн дарга ашиг олдог өнөөгийн буруу тогтолцоог хална.



**Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг төрөөс худалдан авдаг болно.** Үндсэн хуулинд бичигдсэний дагуу мал төрийн хамгаалалтад байна гэсэн зарчмыг хэрэгжүүлэхийн тулд төрийн мал эмнэлгийн сүлжээг сэргээн байгуулж, монгол малыг эрүүлжүүлэн чанаржуулж дэлхийн хамгийн эрүүл органик хүнсэнд албан ёсоор бүртгүүлнэ. Газар тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн тариалсан хүнсний ногоо, тариа буудайг зах зээлийн үнийг харгалзан худалдан авах, дотоод болон гадаад зах зээлд худалдан борлуулах чиг үүрэг бүхий худалдааны компанийг төрийн оролцоотойгоор байгуулна. Ингэснээр газар тариалангийн салбарт бизнес эрхлэгчдэд тулгардаг борлуулалтын хүндрэл арилж, Монгол Улс органик хүнсний бүтээгдэхүүний экспортлогч орон болж хөгжинө.

*Улаанбаатар хотын иргэдэд дараах боломж нээгдэнэ*


**Шинэ хотод шилжин амьдрах боломж нээгдэнэ.** Шинээр баригдах хотуудын бүтээн байгуулалтын ажилд оролцон өндөр цалин хөлс бүхий ажилд шилжих, тухайн хотдоо тав тухтай орон сууцанд орох, шинээр бизнес эрхлэх, үр хүүхдүүддээ сайн боловсрол эзэмшүүлэх зэрэг шинэ хотын иргэдэд олдох бүхий л боломж нээгдэнэ. Өндөр үнэтэй орон сууцны зээл, дэд бүтэцгүй газар хашаа байшин барих зэрэг шинээр гэр бүл болж буй залуу гэр бүлүүд, шилжиж ирсэн оршин суугчдад учирдаг дарамт, хүндрэл арилна.

**Төвлөрөл багассан хотод амьдарна.** Их, дээд сургуулиуд шинэ хотуудад хуваагдан шилжих, зарим иргэд шинэ хотуудад очиж суурьшсанаар өнөөгийн нийслэлийн иргэдийн хэт төвлөрөл багасах учир авто замын түгжрэл, хүүхдийн сургууль цэцэрлэгийн багтаамж хүрэлцээ, эрүүл мэндийн болон бусад төрийн үйлчилгээний ачаалал эрс буурна.

**Утаагүй хотод амьдарна.** Шинээр баригдах цахилгаан станцын үйлдвэрлэх 3500 МВт-ын эрчим хүчний шинэ эх үүсвэр нь эрчим хүчний үнийг хямдруулах учир айл өрх бүр халаалтаа цахилгаанаар шийдэх боломж нөхцөл бүрдэнэ. Утаагүй болсон өнөөгийн гэр хороолол жинхэнэ “Хаус хороолол” болж өөрчлөгдөнө.

**Цэвэр цэмцгэр, үзэмжтэй хотын иргэд болно.** Өнөөгийн гэр хороолол ирээдүйн “Хаус хороолол” болон өөрчлөгдөх тул гудамж замыг хатуу хучилттай болгоно. Тоосгүй замаар, хоггүй гудамжаар зорчих, алхах орчин нөхцөл бүрдэнэ. Хог боловсруулах үйлдвэрийг иж бүрнээр нь барьж байгуулна. Хог хаях газар, хог ачих машин, хог боловсруулах үйлдвэрүүдийг нэгдсэн системд оруулна.

**Монгол Улс хөгжин дэвжих тусам манай улс орны гадаад харилцаа өргөжин бэхжинэ.** Эдийн засгийн үсрэнгүй хөгжил нь манай улс орны гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн гадаад харилцааг идэвхжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, манай улсад үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай болж, илүү борлогдох боломж бололцоо нь нэмэгдэнэ. “Хөршөө сонгогдоггүй” учир хөрштэйгээ найрсаг харилцаа хөгжүүлэх зарчимд тулгуурлан ОХУ болон БНХАУ-тай тогтоосон уламжлалт хөршийн харилцаагаа цаашид улам гүнзгийрүүлдэн хөгжүүлнэ. Түүнчлэн Монгол Улсын хөгжил дэвшил, аюулгүй байдалд нөлөө бүхий бүс нутгийн улс орнууд, Ази, Европ, Америк зэрэг тивийн улс орнуудтай тогтоосон харилцаагаа баяжуулан идэвхжүүлнэ. Монгол Улс гадаад харилцаандаа идэвхтэй, найдвартай түнш байх болно.



“Хөгжлийн хувьсгал” мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол хүн эх орондоо болон хувь заяандаа жинхэнэ эзэн болж, авъяас чадвараа нээн хөгжүүлж, эрдэм боловсролтой, эрүүл саруул болж, ажлын байраар хангагдаж, орлого нь нэмэгдэж, монгол өрх бүр эв найртай, амар амгалан, аз жаргалтай амьдрах таатай нөхцөл бүрдэж, Монгол Улс хоцрогдсон орон байхаа больж, хөгжилтэй орны тоонд орно.

Гэхдээ эхлээд Сонгогч Та эр зориг гарган МАХН-тай хамтран Сонгуулийн хувьсгал хийж, МАХН-аас нэр дэвшигчдийг тууштай дэмжин сонгож, МАХН-д Засгийн газраа байгуулан “Хөгжлийн хувьсгал” мөрийн хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх боломж олгох үүргээ ухамсартайгаар биелүүлж, Монголоо аврах их үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулна гэдэгт итгэж байна.

МАХН Монгол хүн Тантай ямагт хамтдаа!

Монгол Улс маань мандан бадрах болтугай!



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.24 № 800

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Нийцлийн талаарх дүгнэлт**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Монгол Ардын Хувьсгалт намын “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.




**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намаас ирүүлсэн “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

**Дүгнэлт**

Монгол Ардын Хувьсгалт намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Монгол Ардын хувьсгалт намд



A.ЗАНГАД